



# Техникийн бус хураангуй тайлан

“Клин Энержи Ази” ХХК

2016 оны 5-р сарын 12

# Агуулга

Бүлэг	Сэдэв	Нүүр
<b>1</b>	<b>Танилцуулга</b>	<b>1</b>
1.1	Төслийн тодорхойлолт _____	1
1.2	Төслийг хэн хөгжүүлж байна вэ? _____	1
1.3	Төсөл хаана байрлах вэ? Нөлөөллийн талбай гэж юу вэ? _____	1
1.4	Материалууд ба СЦҮ-үүдийг хэрхэн тээвэрлэх вэ? _____	5
1.5	СЦҮ-үүд хэрхэн цахилгаан үйлдвэрлэдэг вэ? _____	6
<b>2</b>	<b>Төслийн хэрэгцээ шаардлага</b>	<b>7</b>
2.1	Уг төслийг ямар учраас хэрэгжүүлэх шаардлагатай вэ? _____	7
2.2	Төсөл ямар үр өгөөжтэй вэ? _____	7
2.3	Өөр ямар хувилбаруудыг харгалзан үзсэн бэ? _____	8
2.4	Төсөл хөгжүүлэлтийн өнөөгийн явц ямар байна вэ? _____	8
2.5	Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ нь ямар үйл явцтай байдаг вэ? _____	9
2.6	Өнгөрсөн хугацаанд хийсэн хэлэлцүүлэг? Цаашид ямар зөвшилцөлийг явуулах вэ? _____	11
2.7	Төслийн талбайн одоогийн байгаль орчин ба нийгмийн нөхцөл ямар байна вэ? _____	11
2.7.1	Тусгай хамгаалалттай газар нутаг _____	11
2.7.2	Байгаль орчны нөхцлүүд _____	12
2.7.3	Нийгмийн нөхцөл _____	13
<b>3</b>	<b>Төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл ба үр өгөөж</b>	<b>14</b>
3.1	Тойм _____	14
3.2	Сөрөг нөлөөлөл бууруулах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх вэ? _____	20
<b>4</b>	<b>Нэмэлт мэдээлэл</b>	<b>22</b>
4.1	Төслийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг хэрхэн авах вэ? _____	22
4.2	Би хэлэх үгээ хэрхэн хүргэх вэ? _____	22
<b>Хавсралт</b>		
Хавсралт А.	Олон нийтийн гомдол, хүсэлтийн маягт _____	23

# 1 Танилцуулга

Энэхүү техникийн бус хураангуй тайлан (ТБХТ) нь Монгол улсад хэрэгжүүлэхээр төлөвлөж буй Цэцийн салхин цахилгаан станц төслийн (цаашид “Төсөл” гэх) тодорхойлолт, төслийн үр өгөөж, байгаль орчин ба нийгэмд учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээний талаарх товч мэдээллээр хангана. Уг баримт бичигт агуулагдсан мэдээлэл нь СгурЭнержи компаний хийж гүйцэтгэсэн Байгаль орчин ба Нийгэмд Нөлөөлөх Байдлын Үнэлгээ, мөн ТүрнСтөүн ХХК, Натур Френдли ХХК, Монголика ХХК-ний нарийн мэргэжлийн экологич ба шувуу судалгааачидын дүгнэлтүүд дээр үндэслэсэн болно.

## 1.1 Төслийн тодорхойлолт

Уг төсөл нь 25 салхин цахилгаан үүсгүүрээс (СЦҮ-үүд) бүрдэх нийт 50МВт-н суурьлагдсан хүчин чадалтай салхин парк юм. Энэ салхин паркийг Монгол улсын Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт барьж байгуулна. Төсөл одоогоор сонгон шалгаруулах шатанд явж байгаа боловч 2МВт-н чадалтай СЦҮ-үүдийг хэрэглэх талаар авч үзэж байна. СЦҮ-с гадна, салхин турбины дээр суурийн байгууламж, ойролцоогоор 18км урттай газар доор байрлах кабелийн сүлжээг СЦҮ-үүдийн үйлдвэрлэх цахилгааныг цуглуулах, улмаар төслийн талбай доторх дэд станцруу дамжуулах зорилгоор байгуулна. Төслийн талбайн дэд станц нь үйлдвэрлэсэн цахилгааныг 34км урттай цахилгаан дамжуулах 110кВын агаарын шугамаар Төвийн эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбогдсон Таван Толгой Дэд Станцад (ТТДС) дамжуулах болно. Төслийн талбайн доторх автозамын сүлжээг Төслийн барилга угсралт ба ашиглалтын шатанд зориулж байгуулах болно.


## 1.2 Төслийг хэн хөгжүүлэх вэ?

Софтбанк Энержи (49%) болон Ньюком Групп (51%)-ийн харьяа компани болох Клин Энержи Азия ХХК (Төсөл хэрэгжүүлэгч)- аас энэхүү төслийг хэрэгжүүлж байна. Ньюком Групп нь Монгол улсад сэргээгдэх болон дулааны эрчим хүчний хэд хэдэн төслийг хэрэгжүүлдэг бөгөөд уг төсөлд бага хувьцаа эзэмшигч Софтбанк Энержи нь ихэвчлэн Төсөлтэй холбоотой санхүүгийн хөрөнгө оруулалтын үүргийг гүйцэтгэж байна.

## 1.3 Төсөл хаана байрлах вэ? Нөлөөллийн талбай гэж юу вэ?


Уг төсөл нь Улаанбаатар хотоос өмнө зүгт ойролцоогоор 542 км зайд Өмнийн говийн бүс нутаг дахь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байрлана. Энэ газар нутаг нь уудам задгай, цөлөрхөг хээр бөгөөд төслийн талбай нь маш тачир ургамалан бүрхэвчтэй юм. Төсөлд хамгийн ойр орших суурин газар болох Цогтцэций сум нь төслөөс хойд зүгт ойролцоогоор 22 км зайд оршино. Тус нутгийн нүүдэлчин ахуйтай малчид улирлын чанартай малаа бэлчээдэг бөгөөд Төслийн талбайн зүүн урд буюу Цэций уулын ойролцоо өвөлжиж, тэнд байрлах гар худгийг ашигладаг байна. Төсөлд зориулсан газар нь төрийн өмчид хамаарагдах бөгөөд тус газар ашиглах зөвшөөрлийг төрөөс авсан. Зураг 1.1-д төслийн байршилыг үзүүлэв. Зураг 1.2 –г зөвшөөрөлтэй газрын хойд буланд байршуулсан СЦҮ-үүдийн байршилыг үзүүлэв. Мөн төслийн талбай ба түүний ойролцоох газрын байр байдлыг харуулах зорилгоор Төслийн талбай дээрээс авсан фото зургыг Зураг 1.3-т тусгав.

Зураг 1.1: Цэцийн салхин станцын байршил



Эх сурвалж: Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, Сгур Энержи, 2016

Зураг 1.2: Төслийн зөвшөөрөлтэй талбай ба төлөвлөж буй СЦҮ-үүдийн байршил, СЦҮ-ийн СТГ-н яригдаж буй төлөвлөлтийн хэд хэдэн хувилбаруудыг ялгаатай өнгөөр үзүүлэв.



Эх сурвалж: Google Earth Pro-г, зөвшөөрөлтэй авч хэрэглэсэн.

Зураг 1.3: Төслийн талбайн газрын гадаргын ерөнхий хэв шинж ба хүрээлэн буй орчны зургууд.



Эх сурвалж: Мотт МакДоналд

Төслийн бүрдэл хэсгүүд:


- 78, 80 эсвэл 95м өндөр цамхагтай, 130м далбаа бүхий нийт 50МВт-ын суурилагдсан хүчин чадалтай 25 ш СЦҮ-үүд (Vestas V100-2.0 МВт, V110-2.0 МВт эсвэл Gamesa G97-2 МВт зэрэг гурван янзын загвар одоогийн байдлаар яригдаж байна).
- Төслийн талбайн дэд станц болон байнгын ажиллагсадын байр ба төв оффис зэргээс бүрдэх удирдлагын төвийн бүрдэл.
- СЦҮ-үүд ба дэд станцыг холбох газар доогуур байрлах цахилгаан цуглуулах систем.
- Удирдлагын төвийндэд станцаас Цогтцэций сумын баруун талд байрлах ТТДС дахь эрчим хүчний нэгдсэн систем хүртэлх 34км урттай 110кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугам.
- Хатуу хучлагатай автозамаас Төслийн талбай хүртэлх, удирдлагын төвөөс СЦҮ-үүд хүртэл талбай дээр байрлах автозамууд.
- СЦҮ нэг бүрийн яг нарийн байршлыг үнэлгээгээнд суурилан судалж байна.

Төслийн талбайгаас баруун хойд зүгт нүүрсний хоёр томоохон ил уурхай болох Таван Толгой болон Ухаа Худаг байрлана. Таван толгой уурхайг төрийн өмчит “Эрдэнэс Таван Толгой” компани, Ухаа худаг нүүрсний уурхайг “Энержи Ресурс” компани тус тус эзэмшдэг. Таван Толгойн нүүрсний уурхай нь төслийн талбайн хилд хамгийн ойрхон буюу 8 км зайтай байрлана.

Зураг 1.4-т цахилгаан дамжуулах агаарын шугамын сонгосон даялалыг үзүүлэв. Уг дамжуулах шугам нь ойролцоогоор 113 ш ган дамжуулах цамхагтай байх ба тус бүрийн өндөр 23м, хоорондын зай нь дунджаар 300м, нийт суурийн мөр ойролцоогоор 0.4га газар байна.



Зураг 1.4: Төслөөс Таван Толгойн дэд станц хүртэлх 110кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамны сонгогдсон чиглэл болон Таван Толгой, Ухаа Худаг нүүрсний ил уурхайнууд.



Эх сурвалж: Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, СгурЭнержи, 2016

Төслийн болон дамжуулах шугамын барилгын ажлын нөлөөллөөс гадна дараах болзошгүй нөлөөллийг мөн тогтоосон:

- СЦҮ-үүдийн үзэгдэх орчны нөлөөлөлтэй холбоотой ландшафт болон орчны үзэмжинд үзүүлэх нөлөөлөл Барилга угсралт, ашиглалтын үеддүү чимээний түвшин нэмэгдэх газрууд.
- СЦҮ тус бүрийн ойролцоо роторын диаметрийг 10 дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээтэй сэнсний сүүдэрний анивчих нөлөөлөл.
- Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаатай холбоотой сэнсний далбаанаас мөс, механик эд зүйл шидэгдэж болзошгүй талбай.
- Салхин паркийн талбай болон дамжуулах шугамын дагуу хээрийн шувууны төрөл зүйлд нөлөөлөх талбай

#### 1.4 Материалууд ба СЦҮ-үүдийг хэрхэн тээвэрлэх вэ?

Төслийн талбайд нэвтрэх замууд нь Гашуун Сухайт боомт дахь Хятадын хил хүртэл үргэлжлэх, уурхайн операторийн эзэмшилд байдаг хатуу хучилттай, засмал замтай холбогдоно. Улаанбаатараас төслийн талбайд барилгын тоног төхөөрөмжийг авчрахад энэ чиглэлийн дагуух замын хөдөлгөөнд бага зэргийн сөрөг нөлөөлөл учруулж болзошгүй.


Барилгын ажлын улмаас орон нутгийн автозам дээрх хүнд даацын тээврийн хэрэгслүүд олширч, замд эвдрэл учруулж болзошгүй. Ерөнхийдөө одоогийн тээвэрлэлтийн дэд бүтцэд үзүүлэх нөлөөлөл нь багаас ялимгүй зэрэглэлийн нөлөөлөлд хамаарагдах бөгөөд уг нөлөөлөл богино хугацаанд

үргэлжлэнэ. Орон нутгийн иргэдэд үр өгөөжтэй байх үүднээс төслийн барилга угсралтын ажлын явцад автозамуудыг шинэчлэн сайжруулна.

### 1.5 СЦҮ-үүд хэрхэн цахилгаан үйлдвэрлэдэг вэ?

Салхин цахилгаан үүсгүүр нь далбаа буюу сэнс, генератор болон бүхээг ба цамхаг гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэнэ. Байгалийн салхи сэнсний далбааг эргэлдэнд оруулахад бүхээг дотор байрлах генераторын үйлчлэлтэйгээр цахилгаан үйлдвэрлэгдэнэ. Эргэлдэх хөдөлгөөнд орсон генераторын ороомог нь соронзон туйл бүхий орныг огтлон гарснаар тогтмол гүйдэл үүсч улмаар цахилгаан үйлдвэрлэгддэг. Уг гүйдлийг хувьсах цахилгаан болгон хувиргаж улмаар трансформаторын тусамжтай өсгөж дэд станцад өгдөг. Зураг 1.5-д ердийн салхин цахилгаан үүсгүүрийн бүрдэл хэсгүүдийг үзүүлэв.

Зураг 1.5: Ердийн салхин турбины бүрдэл хэсгүүд





## 2 Төслийн хэрэгцээ шаардлага

### 2.1 Уг төслийг ямар учраас хэрэгжүүлэх шаардлагатай вэ?

Монгол улс нь хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулж, нар, салхи, ус, газрын гүний дулаанд суурилсан эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилготой үндэсний хөтөлбөрийг баталсан. 2020 он хүртэл Засгийн газраас үндэсний хэмжээнд үйлдвэрлэж буй нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 20-25 хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс хангах зорилт тавин ажиллаж байна.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд үйлдвэрлэж буй нийт цахилгааны 95%-ийг нь нүүрснийн эх үүсвэрээс гаргаж байгаа бөгөөд төвийн эрчим хүчний систем нь нийслэл Улаанбаатар хот, бусад 3 хот, 6 аймгийн хэрэгцээг нүүрсэн галлагаатай дулаан, цахилгаан хосолсон станцуудаар хангадаг бол бусад аймаг сумдын эрчим хүчний хэрэгцээг нүүрсэн галлагаатай ДЦС-ууд болон дизель цахилгаан станцаар тус тус хангадаг. Одоогийн байдлаар эдийн засгын болон үйл ажиллагааны хувьд үр ашиг муу, баталгаа багатай дулаан, цахилгааны хангамж нь хөдөө орон нутгийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа бөгөөд жил бүр эрчим хүчний эрэлт хэрэгцээ 5-7 хувиар өсөж байгаагаар холбогдуулан эрчим хүчний системийн оргил ачааллын үед шаардлагатай нэмэлт цахилгааныг ОХУ-аас импортолсон хэвээр байна.

Өнөөдрийн байдлаар Монгол улсад нэгдсэн сүлжээнд холбогдсон цорын ганц том хэмжээний бие даасан сэргээгдэх эрчим хүчний төсөл болох 50МВт хүчин чадалтай Салхит салхин парк төсөл хэрэгжсэн бөгөөд үүнээс гадна хоёр салхин цахилгаан станцын төсөл санхүүжилтын шатандаа байгаа ажээ. Үүний нэг нь манай орны зүүн урд зүгт байрлах 52 МВт -н Сайншанд салхин парк юм. Монгол улсад салхиар эрчим хүч үйлдвэрлэж, үндэсний хэмжээнд эрчим хүч үйлдвэрлэх зорилго биелүүлэх бүрэн бололцоотой хэмээн АНУ-н Эрчим хүчний департаментын боловсруулан Монгол орны салхины нөөцийн зурагт (2001) үзсэн байдаг. Уг төслийн зорилго нь хөдөө орон нутагт нүүрснээс хэт хамааралтай цахилгаан үйлдвэрлэлийг бууруулж, салхины эх үүсвэрийг ашиглаж эрчим хүч үйлдвэрлэн Монгол улсын эрчим хүчний оргил ачааллыг шийдвэрлэхэд оршино.

Түүчнлэн энэ байрлалд цахилгаан үйлдвэрлэх нь хамгийн тохиромжит хувилбар гэж үзсэн.

### 2.2 Төсөл ямар үр өгөөжтэй вэ?

Төсөл нь дулааны цахилгаан станцыг бодвол хүлэмжийн хийг ялгаруулдаггүй учир байгаль орчинд эерэг үр дагавартай. Энэ Төслийг хэрэгжүүлснээр жилд ойролцоогоор 230,000 тонн хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулж, 180,000 тонн нүүрс, 1.2 сая тонн ус

хэмнэнэ. Мөн түүнчлэн салхин парк эрчим хүч үйлдвэрлэснээр гаднаас импортлогдох нийт цахилгааны хэмжээг бууруулна<sup>1</sup>.

Мөн энэхүү төслийг хэрэгжүүлснээр төмөр зам, авто зам, цахилгаан зэрэг дэд бүтцийн ирээдүйн хөгжилд эерэг нөлөөтэй болно.

### 2.3 Төслийн бусад хувилбаруудыг харгалзан үзсэн эсэх?

Цэцийн талбайг АНУ-н Эрчим хүчний департаментийн боловсруулсан Монгол орны салхины нөөцийн атласт (2001) үндэслэн сонгосон бөгөөд 2008 онд төсөл хэрэгжүүлэгч компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций суманд нийт 7,290 га газрын ашиглах зөвшөөрөл авч, тухайн газарт салхин парк байгуулах боломжийг судалж ирсэн. Салхин паркийн нийт цэвэр талбай нь 700 га бөгөөд зөвшөөрөл авсан томоохон газраас энэ талбайг сонгохдоо техник эдийн засгийн үндэслэл, БОННБҮ-нд үндэслэсэн юм. Салхины мэдээлэл болон техник эдийн засгийн үндэслэлийн дүгнэлтээр уг талбайн тохиромжтой хэмээн үзсэн учир бусад талбайн хувилбаруудыг дахин харгалзаж үзээгүй болно. Харин технологийн өөр хувилбарууд нь СЦҮ-үүдийн ялгаатай загварууд болно.

Монгол улсын засгийн газар нь 2020 хүртэл улс орны цахилгаан үйлдвэрлэлийн 20-25%-ийг сэргээгдэх эх үүсвэрээс хангаж, сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа тул “төсөл хэрэгжүүлэхгүй байх” хувилбарыг авч хэлэлцээгүй болно.

### 2.4 Төсөл хэрэгжүүлэлтийн өнөөгийн явц ямар байна вэ?

Төсөл хэрэгжүүлэх шатанд төрөл бүрийн зөвшөөрөл, баталгааг гаргуулан авах үйл явц багтана. Монгол улсын Үндсэн Хуульд байгаль орчныг хамгаалах хууль эрх зүйн тогтолцоо нь байгаль орчныг хамгаалах дотоодын болон олон улсын хуулиудаас бүрдэнэ хэмээн заасан байдаг. Үндсэн хуульд хэд хэдэн байгаль орчны зүйл заалтыг тусгасан байдаг. Засгийн газраас байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа хариуцан явуулах Байгаль Орчин, Ногоон Хөгжил, Аялал Жуулчлалын яам (БОНХАЖЯ) зэрэг төрийн бүтцийг байгуулж, байгаль орчны шинэ хууль тогтоомжийн тогтолцоог боловсруулсан. БОНХАЖЯам нь Ус, цаг уур, орчны хяналт шинжилгээний агентлаг, Газрын агентлаг, Сав газрын зөвлөл зэрэг хэд хэдэн харьяа агентлагуудыг удирдан ажилладаг бөгөөд Монгол улсын хэмжээнд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг нарийвчлан (БОНБНҮ) хийх шаардлагатай эсэхийг тус яам тодорхойлдог.

БОНХАЖЯамнаас уг Төсөлд БОНБНҮ-ийг хийх шаардлагатай гэж мэдэгдсэн ба үүний дагуу БОНБНҮ-г 2014 онд хийж гүйцэтгэсэн. Улмаар БОНХАЖЯамнаас төслийн хэрэгжилтийг дараах нөхцөлтэйгээр хүлээн зөвшөөрсөн тухайлбан ёсоор мэдэгдсэн. Үүнд:

- Байгаль орчны суурь нөхцлүүд
- Төслийн зураг төсөл болон боломжитөөр хувилбаруудын талаарх дүн шинжилгээ,

---

<sup>1</sup> Information Memorandum, CEA (2015)

- Сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах, бууруулах арга хэмжээ болон болзошгүй ба ноцтой сөрөг нөлөөллүүдийг арилгах санал зөвлөмжүүд.
- Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, үр дагаварт дүн шинжилгээ, тооцоо хийх.
- Осол болон эрсдлийн тооцоо гаргах.
- Байгаль орчныг Хамгаалах Төлөвлөгөөг эсвэл Байгаль орчны Менежментийн Төлөвлөгөө.
- Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр.
- Оролцогч талуудын хэлэлцүүлэг.

БОНБНУ-г батлуулахын зэрэгцээ дараах чухал зөвшөөрлийг авах шаардлагатай:

- Газар ашиглах гэрчилгээ
- Эрчим хүчний үйлдвэрлэл байгуулах тусгай зөвшөөрөл
- Дамжуулах шугаманд зориулсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ (БОНБҮ) эсвэл БОНБНУ
- Газар ашиглах гэрээ
- Газрын гүний ус ашиглах зөвшөөрөл
- Түр зуурын ажилчыг байрлуулах зөвшөөрөл

Салхин цахилгаан үүсгүүр байрлуулах, байнгын ашиглах авто зам, трансформаторын станцуудыг барих зэрэг зориулалттай газрын эрхийгурт хугацааны газар ашиглах гэрээний үндсэн дээр баталгаажуулсан болно. Яамнаас тавигдсан нөхцөл шаардлагын дагуу БОНБНУ-ийг 2014 онд хийж гүйцэтгэсэн бөгөөд 2017 онд төслийн барилга угсралтын ажил эхлэх төлөвтэй байна. Одоогийн байдлаар бусад шаардлагатай зөвшөөрлийг авах ажил хийгдэж байна.

## 2.5 Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ нь ямар үйл явцтай байдаг вэ?

Төсөл хэрэгжүүлэгч нь улсын хэмжээнд шаардагдах БОНБҮ-г гүйцэтгэх ажлаас гадна байгаль орчин, нийгмийн судалгааг Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Байгаль Орчин ба Нийгмийн Бодлого (БОНБ) 2014-т заасан нөхцлийн дагуу хийж гүйцэтгэсэн. Энэ бодлогын баримт бичигт байгаль хамгаалал, нийгэм болон байгаль орчны эрсдлийн менежмент, мэдээллийн ил тод нээлттэй байдал, талуудын оролцоог хангах тухай Европын Холбооны (ЕХ) захирамжууд зэрэг ЕХ-ний байгаль орчны хууль тогтоомжуудын үндсэн зарчим тусгагдсан байдаг.

ЕСБХБ нь уг төслийг БОНБ-ний дагуу үнэлж “Б” ангиллын төсөлд оруулсан байдаг. “Б” зэрэглэлийн төслийг “ирээдүйд байгаль орчин ба нийгэмд үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөлөл нь ерөнхийдөө төслийн талбай төвтэй, эсвэл хялбархан тогтоож, бууруулах арга хэмжээ авч болохуйц төсөл” хэмээн тодорхойлдог байна.

Хүснэгт 2.1: ЕСБХБ-ний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн хамааралтай эсэх - 2014)

ЕСБХБ-ний Гүйцэтгэлийн Шалгуур	Тайлбар	Төсөлд хэрэглэгдэх эсэх?
ГШ1: Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл ба менежмент	Төсөл хөгжүүлэлтийн эхэн шатанд байгаль орчин, нийгэмд учрах нөлөөллүүдийг үнэлж, тэдгээрийг тогтмол хянаж, удирдах шаардлага.	Тийм
ГШ2: Ажиллах хүч ба хөдөлмөрлөх нөхцөл	Ажлын байр, орлогын эх үүсвэрийг бий болгосноор эдийн засгийн өсөлтөнд нөлөөлж, ажилчдын үндсэн эрх, эрх чөлөөг хамгаална. Мөн ажилчид болон удирдлага хооронд зүй зохистой харилцаа үүсгэж, ажилчидтай шударга, ялгаваргүй харьцах, эрх тэгш боломж олгоход анхаарах.	Тийм
ГШ3: Нөөцийн үр ашиг, бохирдлоос сэргийлэх ба хянах	Төслийн түвшинд бохирдлоос сэргийлэх ба хянах, түүнчлэн Европын болон ОУ-н хууль тогтоомж, туршлагад нийцсэн нөөцийн үр ашигтай хэрэглээг шаарддаг.	Тийм
ГШ4: Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа	Төсөлтэй холбоотой үйл ажиллагаанаас нутгийн иргэд, ялангуяа эмзэг бүлгийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба хамгаалалд учруулж болзошгүй нөлөөлөл, эрсдлээс зайлсхийх, хамгийн бага хэмжээнд байлгах хариуцлагын тогтолцоог шаарддаг.	Тийм
ГШ5: Газар чөлөөлөлт, Сайн дурын биш нүүлгэн шилжүүлэлт ба түүнтэй холбоотой эдийн засгийн хохирол	Төслийн газар эзэмших хууль ёсны эрхийн дагуутөслийн газар чөлөөлөлтийг албадан явуулах үед тохиолдоно. Нүүлгэн шилжүүлэлт нь бодитоор явагдах нүүлгэлт (сэлгэн байршуулах эсвэл орон байраа алдах) болон эдийн засгийн шилжүүлэлт (газар дээрх хөрөнгөө алдах эсвэл газар дээрх хөрөнгөд нэвтэрч чадахгүй болсноор орлогын эх үүсвэр болон бусад хохирол) зэрэг болно.	Тийм
ГШ6: Биологийн олон янз төрөл зүйлийг хамгаалах болон байгалийн ан амьтны нөөцийн тогтвортой менежмент	өслийн үйл ажиллааны улмаас биологийн төрөл зүйлд аюул учруулахаас зайлсхийх, нөлөөлөл бууруулах, байгалийн сэргээгдэх нөөцийг тогтвортой хэлбэрээр ашиглахыг шаарддаг. Амьтны амьдрах орчинд нөлөөлөл бол төсөл нь биологийн төрөл зүйлийн олон янз байдлыг “цэвэр ашиг” ба “цэвэр алдагдалгүй байх” зорилтыг эрхэмлэнэ	Тийм
ГШ07: Уугуул иргэд	Нийгмийн үндсэн бүлгүүдээс гадна хүн амын цөөнх болсон эмзэг хэсэг болох нутгийн уугуул иргэдийн эрхийг хамгаалах..	иТөсөл хэрэгжих газарзүйн байрлалд уугуул иргэд байхгүй.
ГШ08: Соёлын өв дурсгал	Төслийн үйл ажиллагааны үеэрсоёлын өв дурсгалыг хамгаалах, тэдгээрийн хадгалалт,хамгаалалыг дэмжихийг төсөл хэрэгжүүлэгчээс шаарддаг.	Тийм
ГШ09: Санхүүгийн зуучлагчид	ЕСБХБ нь санхүүжилтийг санхүүгийн зуучлагчид буюусанхүүгийн үйлчилгээ олгогчид дамжуулан олгох үед хэрэглэнэ.	Үгүй –Нэмэлт зээлдүүлэгчид оролцох боловч ЕСБХБ нь

		төслийг шууд санхүүжүүлнэ.
ГШ10: Мэдээллийн ил тод байдал, талуудын оролцоог хангах	Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй оролцогч талуудыг тодорхойлж, тэдгээрт төслөөс үүсэх нөлөөллийн талаар хангалттай мэдээллээр хангах, төслийн бүх үе шатанд оролцогч талуудтай соёлын хувьд хүндэтгэлтэй байдлаар ойлголцох, тогтмол уулзах, Төслийн болзошгүй сөрөг нөлөөллүүд ба эрсдэлтэй холбогдох гомдол барагдуулах механизмаар хангахыг төсөл хөгжүүлэгчээс шаарддаг.	Тийм

Дотоодын үндсэн шаардлага болсон БОНБНУ-нь Сгур Энержи компаний олон улсын стандартын дагуу бэлтгэсэн Байгаль орчин, нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээгээх улам баяжуулагдав. Уг БОННБҮ-ээр салхин цахилгаан станц ба дамжуулах шугамыг хамруулан олон улсын зээлдүүлэгч байгууллагуудын шаардлагад нийцсэн үнэлгээг явуулах зорилготой байв.

## 2.6 Өмнө нь зохион байгуулсан уулзалт? Цаашид ямар хэлэлцүүлэг уулзалт явуулах вэ?

Сэргээгдэх эрчим хүчний аливаа төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдийн саналыг тусгах асуудлыг тусгахаар Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн нэмэлт өөрчлөлтийнажил одоогоор хийгдэж байна. Дотоодын БОНБНУ-г гүйцэтгэх хугацаанд олон нийтийн хэлэлцүүлгийг явуулаагүй боловч олон улсын БОННБҮ-нд зориулж дөрвөн удаагийн уулзалтыг оролцогч талуудтай зохион байгуулж төслийн талаарх мэлээлэлболон БОННБҮ-ний үйл явцын талаар иргэдэд танилцуулсан. БОННБҮ-ний мэргэжлийн судалгаануудыг дуусгасны дараа энэхүү тайланг олон нийтэд ил болгох төлөвлөгөөтэй ажиллаж байна (2016 оны 3-р сард төлөвлөгдсөн).

Оролцогч талуудын уулзалтын төлөвлөгөө (ОТУТ)- г боловсруулсан бөгөөд энэ баримт бичгийн хүрээнд БОННБҮ-г ил тод нийтлэн, төслийн барилга угсралт, ашиглалтын явцад зөвшилцөлд оролцох оролцогч талуудыг тодрхойлно. ОТУТ-ийг уг баримт бичгийн хамт олон нийтэд мэдээлж, ил тод болгоно.

## 2.7 Төслийн талбайн одоогийн байгаль орчин ба нийгмийн нөхцөл ямар байна вэ?


### 2.7.1 Тусгай хамгаалалттай газар нутаг

Төслийн талбай нь олон улс болон үндэсний хэмжээнд байгаль хамгаалал буюу Биологийн олон янз байдлын (ө.х. биологийн олон янз байдлын үнэ цэнээр өндөр газар нутаг) хамгаалалд хамааралтай газар нутагт шууд байрладаггүй. Гагцхүү төслийн талбай нь өргөн хүрээний хувьд Цэций Уул Тусгай Хамгаалалттай Газар Нутагын хил (ТХГН) дотор шууд байрлана.

Зураг 2.1-д орон нутгийн ТХГН-н хамгийн сүүлийн үеийн хилийн хязгаарийг үзүүлсэн ба энэ нь Цогтцэций сумын иргэдийн төлөөлөгчдийн зөвлөлийн 2015 оны 5-р сарын 2-ний өдөр баталсан орон нутгийн хамгаалалттай газрын тухай тогтоолд үндэслэсэн ажээ.



Зураг 2.1: Цогтцэций сумын Тусгай хамгаалалттай газар нутгууд



Source: Environ

### 2.7.2 Байгаль орчны нөхцлүүд

Зөвшөөрөлтэй газрын талбай ойролцоогоор 7,290 га хэмжээтэй, зэлүүд, харьцангуй тэгш удам, тачир ургамалжилттай цөлөрхөг хээрийн бүст хамаарагдах бөгөөд д.т.д дунджаар 1550м өндөрт өргөгдсөн болно. Төслийн талбайн жилийн дундаж хур тунадасны хэмжээ нь 99.4мм ба зуны улиралд түүний 94.3% нь бороо хэлбэрээр орж, өвлийн улиралд 5.7% нь цас хэлбэрээр орно. Хаврын улиралд хүчтэй шороон шуурга тохиолдоно.

Салхин паркийн талбайн 700 га барилгажих талбайн дотор эсвэл ойролцоо гол горхи, гадаргын усан сан байхгүй. Цэций уулын орчим талбайн өмнө хэсэгт нүүдэлчин малчдын гараар гаргасан худгууд байдаг. Цэций суурингийн ойролцоо 50 орчим булаг шанд байдаг тухай мэдэгдсэн боловч уг тоо нь сумын хэмжээнд 5 болтлоо буурсан байна. Түүнчлэн Цогтцэцийн усан дахь эрдэс бодисын агууламж өндөр тулундны усны эх үүсвэрт үзүүлэх төслийн нөлөөллийг анхаарах шаардлагатай асуудал юм.

Төслийн газрын гадарга нь хүчтэй болон дунд зэргийн газар хөдлөлтийн улмаас эрчимтэй хагарал, цууралт өгч ихээхэн элэгдсэн байна.

Төслийн талбайд жижиг овооноос өөр бусад археологи, соёлын үнэт зүйлүүд илрээгүй болно. Эдгээр овооны хил хязгаар, зүг чигийг заагч хэмээн иргэд үздэг бөгөөд соёлын хувьд хязгаарлагдмал ач холбогдолтой хэмээн хэлэлцүүлгийн үеэр тэмдэглэжээ.

Шувуу судалгааны талбайг (хээрийн судалгааны талбай) төслийн талбай болон Цэций Уул ТХГН-н ойролцоо 20км байна хэмээн үзсэн. Нийт 53 суурин байрших үржлийн шувууны төрөл зүйлийг хээрийн судалгаагаар төслийн талбайгаас илрүүлсэн бөгөөд үүнээс 3 зүйл нь салхин паркийн барилга угсралтын талбайдтэмдэглэгджээ. Төслийн талбай болон нийт судалгааны талбай нь нүүдлийн шувуудын Төв Азийн нислэгийн зам дагуу байрлах боловч хавар, намрын нүүдлийн үед явуулсан хээрийн судалгааны турш цөөхөн тооны шувууд тэмдэглэгдсэн. Төслийн талбайг нүүдлийн шувууд олноор цугларах талбай гэж үзэхгүй бөгөөд тус талбайд шувуудад шаардлагатай гадаргын усан сан ба хооллон амьдрах орчин дутмаг тул нүүдлийн шувуудын зогсож-амрах цэг биш хэмээн дүгнэжээ.

### 2.7.3 Нийгмийн нөхцөл

Цогтцэций сумын хүн ам сүүлийн жилүүдэд үндсэндээ уул уурхайн өсөлтийн улмаас хурдацтай өсөж байна. Харин төслийн зөвшөөрөлтэй газрын эргэн тойрон талбайд хүн ам сийрэг суурьшсан. Тус орон нутгийн эдийн засаг нь уламжлалт мал аж ахуй болон уурхайн салбарын ажил эрхлэлтээс хамааралтай.

Өнөөгийн хүн амын өсөлт нийгэм ба олон нийтийн дэд бүтцэд ачаалал болж байгаа боловч өсөж буй эрэлт хэрэгцээг хангахын тулд Цогтцэций сумд шинэ эмнэлгийг барьсан байна. Мөн орон нутгийн уул уурхайн компаниудын санхүүжилтээр шинэ бүрэн дунд сургуулийг барьсан.

Тухайн нутгийн эрүүл мэндийн гол асуудлуудын нэг нь ундны усны чанар ба цэвэр усны хангамжтай холбоотой юм. Сумын төвөөс гадна орших малчин өрхүүд гар худаг ашиглан ундны усны хэрэгцээгээ хангадаг.

## 3 Төслийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөлөл ба үр өгөөж

### 3.1 Тойм

Хүснэгт 3.1-д Төслийн барилга угсралт, ашиглалтын үе шаттай холбогдох БОНБНҮ /БОННБҮ-ээр тогтоогдсон байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг болонсөрөг нөлөөллүүд, тус нөлөөллийн түвшинг хүлээн зөвшөөрөгдөх түвшин хүртэл бууруулах, зайлуулах арга хэмжээнүүдийг тайлбарлав.

**Хүснэгт 3.1: Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллүүд, тэдгээрийг бууруулахаар санал болгож буй арга хэмжээнүүдийн талаарх дүгнэлт**

#### Ус

Салхин парк болон цахилгаан дамжуулах агаарын шугамын барилга угсралтанд шаардагдах усны нийт ашиглалтын хэмжээг 18 сарын турш 49,813м<sup>3</sup> байна гэж тооцоолсон. Энэхүү усны хэрэгцээг Таван Толгойн уурхай эсвэл Цогтцэций сумаас хангахаар санал болгосон. Ингэснээр сум эсвэл уурхайд усны нэмэлт ачаалал үүсгэж болохыг БОННБҮ-ээр тогтоосон болно. Төсөл хөгжүүлэгч компани нь усны нөөцийн хүрэлцээг үнэлэх, нутгийн оршин суугч, малчдад сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр Төслийн усаар тогтвортой хангаж болох хэмжээг тодорхойлох судалгааг явуулна. Энэ судалгаагаар төслийн талбайд ойрхон байрлах малчдын ашигладаг худагт нөлөөлөхгүйгээр усыг хангаж чадах хангалттай хэмжээний ус агуулсан давхарга боломжийн гүнд байгаа эсэхийг судална.

Хэрвээ судалгааны үр дүнд усыг тогтвортой замаар ашиглах боломжгүй нь тогтоогдвол усыг өөр газраас талбай руу хүргэх хувилбарыг сонгоно.

Төслийн талбай орчим гүний ус нь ундны усны чанарыг хангахгүй тул төслийн талбайд шинээр худаг гаргахгүй гэсэн таамаглалтай байгаа тул гүний усанд үзүүлэх барилгын нөлөөллийг бага зэрэг хэмээн тогтоосон. Бохирдсон усны урсацааргазарт бохирдох эрсдлийг хамгийн бага байлгах шилдэг арга туршлагауудыг барилга угсралтын шатанд хэрэгжүүлнэ.

#### Хог хаягдал (аюултай ба аюулгүй)

Бүх төрлийн хатуу хог хаягдлыг зохих хаягдал зайлуулах байгууламжруу тээвэрлэн хүргэхээс өмнө хог хаягдлыг төслийн талбайд цуглуулж, түр хадгална. Энэ талаарх нарийн төлөвлөгөөг тусгасан Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулна. Мөн махчин шувууд, сэгээр хооллогчдийг хог хаягдлын цэгт татахгүйн тулд савлагаагүй хоол хүнсний хаягдал, бусад хогийг ил задгай хаяхаас сэргийлнэ.

---

## Хөрсний элэгдэл

Нэвтрэх замаар талбайгаас орж, гарах ажилчид, тоног төхөөрөмжийн хөдөлгөөний улмаас замэлэгдэнэ.

Үүнийг бууруулахын тулд бүх төрлийн тээврийн хэрэгслийг зориулалтын замаар зорчуулж, боломжтой газарт зүлэгжүүлнэ. Барилгын эхний ажлууд дуусмагц халцарсан газрыг зүлэгжүүлэх, тогтворжуулах зорилгоор борооны ус зайлуулах суваг, шуудууг ургамалжуулна.

## Дуу чимээ

Төслийн талбайд оршин суугаа дуу чимээний мэдрэг хүлээн авагчдад үзүүлэх өдрийн ба шөнийн цагийн шалгуур үзүүлэлтийг давсан ямарваа дуу чимээний нөлөөлөл байхгүй.

2014 оны хээрийн судалгааны үед төлөвлөж буй салхин паркийн барилга угсралтын талбайд байрлаж буй улирлын чанартай гэр буюу нөлөөлөлд өртөх иргэдийг тогтоосон. Нүүдэлчин малчдад үзүүлэх дуу чимээний эрсдлийг бууруулахын тулд Төсөл хэрэгжүүлэгч компани нь гэрээ хаана буулгавал тав тухгүй байх мөн эрсдлээс зайлсхийж болох талаар мэдээллээр хангах, шийдвэр гаргах боломжийг нутгийн малчдад олгох, тэдэнтэй харилцаж, мэдээлэл харилцан хуваалцах холбоо барих тогтолцоог байгуулна. Энэ ажлыг жил бүр хийх шаардлагатай гэж таамаглаж байна.

## Замын хөдөлгөөн ба Тээвэрлэлт

СЦҮ-ийн бүрдэл хэсгүүдийг Хятад улсад байрлах үйлдвэрээс нь шууд эсвэл бусад газраас худалдан авч, газраар тээвэрлэнэ. Тээвэрлэлттэй холбоотой аливаа ноцтой асуудал илрээгүй болно. Ухаа худагаас Гашуун сухайтын хилийн боомт хүртэл 245 км уртай, шинэ хатуу хучлагатай засмал зам одоогийн нүүрс тээвэрлэх хайрган замын хажуугаар баригдаж дууссан ба уг зам 2011 оны 10-р сараас ашиглалтанд орсон. Хилийн боомтоос төслийн талбай хүртэл уг автозам нь 100 тонн хүртэлх даацтай ачааны машиныг зорчуулах хүчин чадалтай.

Зохих замын хөдөлгөөний менежментийн арга хэмжээг том оврийн ачаа тээвэрлэх үед уг замаар зорчих бусад хэрэглэгчид хамгийн бага хэмжээний саад учруулахаар анхааран хэрэгжүүлнэ. Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдсэнээс замын ерөнхий элэгдэл үүсч, замын зах хэсэгт эвдрэл учруулж болно. Элэгдлийн хэмжээний тооцоог урьдчилан тогтоох хэцүү ч бууруулах арга хэмжээ авсан тохиолдолд дунд зэргийн сөрөг нөлөөлөл учирна хэмээн үзнэ.

Төслийн барилга угсралтын шат дуусахад тоног төхөөрөмжийг төслийн талбайд зөөвөрлөснөөс зам, замын дэд бүтэц болон замын дагуух хувийн эд хөрөнгөд учирсан аливаа нөлөөллийг арилгана.

---

## Ландшафт ба үзэгдэх байдал

Салхин паркийн талбай болон дамжуулах шугамд зориулж ландшафт ба үзэгдэх байдалд үзүүлэх нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийсэн. Уг үнэлгээгээр ландшафтад үзүүлэх нөлөөлөл ноцтой биш болохыг тогтоосон. Уурхай ажилчид болон нүүдлийн гэрүүдийн байрлал дээрх үзэгдэх байдалд учруулах нөлөөллийг дунд зэрэг гэж үзсэн ба ялимгүй хотгор гүдгэр газрын гадаргын байдлын улмаас СЦҮ-үүдийн цамхагийн дунд хүртэлхэсгүүд харагдахгүй. Нэмэлт бууруулах арга хэмжээг санал болгоогүй.

## Экологи ба Байгаль хамгаалал

### Байгаль хамгаалах зорилгоор тогтоосон газрууд

Үнэлгээний дагуу Төслийн талбай нь Цэций уул ТХГН-н бүст хамаарах боловч тус газарт ямар нэг сөрөг нөлөөлөл байхгүй гэж үзсэн.

### Амьдрах орчин ба ургамал

Салхин цахилгаан станцын талбайд хээрийн судалгааны явцад тусгай хамгаалалын ач холбогдолтой ургамлын төхөл зүйл илрээгүй (ө.х. БХОУХ-ний улаан данс эсхүл Монгол орны мэдээллийн улаан данс (МУД)-д устах аюултай гэсэн зэрэглэлд багтсан). Төслөөс ургамлын төрөл зүйлд учруулах сөрөг нөлөөлөл бага тул ургамлын төрөл зүйл хамгаалахаар чиглэсэн онцлог арга хэмжээг санал болгоогүй.

Дамжуулах шугамын чиглэлийн дагуу зарим нэг хязгаарлагдмал нөлөөлөл байх боломжтой. Цаашдаа судалгаа болон Биологийн олон янз байдлын төлөвлөгөөг (БОЯБТ) орон нутгийн хэмжээнд боловсруулахаар төлөвлөж байна.

### Амьтны аймаг

Төслөөс хоёр нутагтан, мөлхөгчдөд үзүүлэх нөлөөлөл маш бага зэрэглэлээс бага зэрэгт хамаарахбөгөөд аливаа зүйлд чиглэсэн онцлог арга хэмжээг авах шаардлагагүй.

Амьдрах орчин алдагдсаны улмаас болзошгүй нөлөөлөлд өртөх хөхтөн амьтны нэг зүйл бол Тавруу атигдаахай юм. Тавруу атигдаахайд учрах нөлөөллийг тухайн амьтдын олдсон талбайгаар холуур СЦҮ-үүдийнг суурилуулснаар бууруулж болно. Ингэснээр амьдрах орчин алдагдсаны улмаас учрах аливаа сөрөг нөлөөллийг маш бага болгоно. Төслийн талбай дээрх малын бэлчээрлэлт болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний одоогийн түвшинтэй харьцуулан үзвэл зээрийн хоёр зүйлд салхин паркаас үзүүлэх нөлөөллүүд нь маш бага байх төлөвтэй юм.

### Сарьсан багваахай

Судалгааны талбайд сарьсан багваахайн нэг зүйл болох Турсаахай (*Hypsuga alaschanicus*) (БХОУХ МУД Анхааралд Өртөөгүй) тэмдэглэгдсэн боловч Төслийн шууд нөлөөллийн талбайд ямар ч сарьсан багваахай тэмдэглэгдээгүй. Судалгааны талбайд сарьсан багваахай маш бага ажиглагдсан тул хээрийн судалгааны үр дүнд үндэслэн үзүүлэх нөлөөллийг маш бага гэж үзсэн.



---

## Шувууд

Төслийн талбайд Идлэг шонхор тохиолдсны улмаас ЕСБХБ-ний ГШ 6-ний дагуу Чухал Амьдрах Орчны үнэлгээг хийв. Уг үнэлгээний дагуу хээрийн судалгааны талбай (төлөвлөж буй Төслийн талбайн 20км) уг зүйлийн амьдрах чухал орчин биш болох нь тогтоогдсон. Тус зүйл төслийн талбайд цөөн тоогоор тохиолдолдох басөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж тооцвол уг шувууны зүйлд үзүүлэх хэмжигдэх сөрөг нөлөөлөл учрах магадлал бага байна. Монгол Ногтруу (Идлэг шонхорын гол өгөөш) ихээр цугласан талбайгаас СЦҮ 1 ба СЦҮ 12-ийг өөр газар байрлуулах бууруулах арга хэмжээ нь шувууг СЦҮ-н сэнстэй мөргөлдөх эрсдлийг бууруулахад тусална.

Тус зүйлийн шувууд (тухайлбалмахчин шувууд зэрэг СЦҮ-тэй мөргөлдөх өндөр эрсдэлтэй байдаг зүйлүүд) төслийн талбайдхарьцангуй хязгаарлагдмал нисдэг учирэдгээр зүйлүүдийн мөргөлдөх эрсдлийг бага буюу ноцтой үр дагаваргүй гэж үзсэн.

Төслийн талбайд БХОУХ-ний Улаан данс болон Монгол орны амьтны МУД-д аюулд орсон зэрэглэлээр бүртгэгдсэн шувууд тэмдэглэгдээгүй. Иймд амьдрах орчны алдагдал, эвдрэл доройтол зэрэг бусад холбогдох нөлөөллүүдийг ноцтой гэж үзээгүй ба аливаа төрөл зүйлд чиглэсэн онцлох арга хэмжээ шаардагдахгүй.

Шувууны нислэгийг өөрчлөгчболон Идлэг шонхорыг дамжуулах цамхаг дээрх цахилгаанд цохиулах эрсдэлтэй хэсгүүдээс холдуулан татах үүрлэх тавцан суулгах зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан тохиолдолд дамжуулах шугамын нөлөөллийг хязгаарлагдмал гэж үзнэ.

БОНМТ-нд бүх зүйлийн бүлэгт зориулсан цаашдын биологийн олон янз байдлын судалгаа, хяналт шинжилгээг санал болгосон. Үүнд бууруулах болон сайжруулах арга хэмжээний хэрэгжүүлэлт, мөн үйл ажиллагааны хяналт шинжилгээний үүргүүдийн талаарх бүрэн мэдээллийг багтаасан. Хэрэгжүүлэх гол бууруулах арга хэмжээнүүдэд шувуу дөхүүлэгч, турбинуудыг нарийн тооцоолж суурилуулах, үүрлэх хайрцаг ба тавцан суулгах зэрэг багтана.

## Сүүдэрaнивчих хөдөлгөөн

Төслийн хэрэгжилтийн үед сүүдрийн анивчих хөдөлгөөний нөлөөллийн хэмжээг хамгийн өндрөөр тооцоолон үзэж нөлөөллийг үнэлсэн. Сүүдэрн анивчих хөдөлгөөний нөлөөлөл нь СЦҮ-үүдийн роторын диаметрээс 10 дахин илүү зайд буюу 1100м-ээс хол зайд маш бага байна гэж үзсэн. Нөлөөлөлд өртөх нэг хүлээн авагч айл тогтоогдсон ба энэ нь салхин паркын талбай доторх улирлын чанартай түр зуурын суурьшилтай гэр байсан. Энэ гэр нь жилд 30 цаг буюу өдөрт 30 минут гаруй хугацаанд сүүдрийн анивчилтад өртөнө гэж тооцоолсон.

Нүүдэлчин соёлтой малчдад учрах эрсдлийг бууруулахын тулд Төсөл хэрэгжүүлэгч

---

---

компани нь малчдыг болзошгүй сүүдрийн анивчих хөдөлгөөнийнөлөөлөлд өртөхөөс сэргийлэхийн тулд гэрээ хаана буулгах талаар мэдээллээр хангана.. Үүнийг жилд нэг удаа хийхээр төлөвлөжбайна.

### Байрлуулах бааз ба хүн амын шилжилт хөдөлгөөн

Барилга угсралтын шатанд 200 хүртэлх ажилтанг төсөлд авч ажиллуулна. Бүх ажиллагсад Төслийн талбай дээр гэр кеппээсбүрдсэн барилгын ажилчдын түр баазад амьдарна. БОННБҮ-ээр хүн амын хамгийн их шилжилт хөдөлгөөн нь сумын одоогийн хүн амын 3%-ийн өсөлттэй тэнцүү байна гэж таамагласан. Үүний улмаас нийт хүн ам болон орон сууцны эрэлтэд бага хэмжээний өөрчлөлт гарах бөгөөд нөлөөллийг бага зэргийн хэмээн үнэлсэн. Ажлын байрны өсөлт нь бага зэргийн үр өгөөжтэй, түр зуурын байх төлөвтэй.

Ажлын байрны өсөлтийн шууд бус нөлөөлөл нь төсөлтэй холбоотой ажил хайж, Цогтцэций сум руу нүүж ирэх хүн амын нэмэлт урсгал юм. 200 ажлын байрыг хайж ирэгсэд нь нийт 800 шинэ оршин суугчдын урсгалыг бий болгох (дундаж өрхийн гишүүдийн тоо 4) ба тэдгээрийн ихэнх нь Цогтцэций сумын төвд байрлана. Бууруулах арга хэмжээгээр усан хангамж, нийтийн эрүүл мэндийн дэд бүтэц, хаягдал усны цэвэрлэх байгууламж зэрэг нийтийн дэд бүтцийг хамруулан орон нутагт үзүүлэх Төслийн шууд бус болзошгүй нөлөөллийг шийдвэрлэх Хүн Амын Шилжилт Хөдөлгөөний Бүдүүвчийг орон нутгийн төрийн байгууллагууд болон бусад компаниудтай хамтран боловсруулах.

### Ажиллах хүч ба хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй

Төсөл нь ажлын байрны орчин, ажилчдын зохион байгуулалт, цалин хөлс, насанд хүрээгүй хүүхэд ба албадан хөдөлмөр эрхлэхийг хориглох, ялгаварлан гадуурхах зэрэгтэй холбоотой Монгол улсын хууль тогтоомжийн шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулна.

Ажиллах хүч ба хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрсдлийг хянахын тулд Төсөл хэрэгжүүлэгч компани нь дотоодын шаардлагууд болон ЕСБХБ-ний БОНБ 2012-т заасан шаардлагуудыг хангасан Хүний Нөөцийн бодлогыг барилга угсралт ба ашиглалтын шатны өмнө боловсруулна. Бүхгэрээлэгчид болон давхар гэрээлэгчдээс Хүний Нөөцийн Бодлогын шаардлагуудыг хэрэгжүүлэхийг шаардах ба Төсөл хэрэгжүүлэгч компани талбай дээрх хэрэгжүүлэлтийг шалгах байнгын аудитуудыг явуулж байна.

### Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба хамгаалалт

Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал ба хамгаалалтад үзүүлэх нөлөөллийг маш бага гэж тогтоосон боловчэрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн төлөвлөгөөг

---

---

Төсөл хэрэгжүүлэгч боловсруулах ба үүнд ажлын талбайд тэмдэг тэмдэглэгээ хийх, хашаалах, жолоочдийг зохих замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааны сургалтад хамруулах (ажиллагсад болон гэрээт ажилчид), гомдол барагдуулах механизмыг ажиллуулах зэрэг малчдад тулгарах аливаа эрсдэл, нөлөөллийг шийдэх арга хэмжээнүүдийг тусгана.

Бусад төлөвлөгөөнүүдэд ослын бэлэн байдал ба хариу үйлдлийн төлөвлөгөө, замын хөдөлгөөний төлөвлөгөө багтана. Эдгээр бүх төлөвлөгөөг ОТУТ-нд тусгасан уулзалт, үйл явдлаар дамжуулан нөлөөлөлд өртөх нутгийн иргэдэд танилцуулна.

### Газар чөлөөлөх, Бие байдлын ба эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт

Салхин парк төслийн үйл ажиллагааны улмаас аливаа байдлаар нүүлгэн шилжүүлэлт тохиолдохгүй гэж тооцоолсон. Өргөн уудам газар нутгийн дийлэнх хэсэг нь төрийн өмчид хамаарагддаг ба малчид бэлчээрийг улирлын чанартай ашигладаг. Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийг хамгийн бага байлгахын тулд Төслийн хашаалах талбайг зөвхөн гол бүрдэл хэсгүүд, оффисын барилгыг тойрсон бага талбайд хязгаарлах ба үлдсэн газрын талбайг хөндлөн огтолож буй шугамыг боломжит хамгийн бага хэмжээнд байлгана. Ажилчдын байрыг талбай дээр байрлуулж, зориулалтын хуучин замаар зорчуулна. Төслийн ажиллагсaдыг зориулалтын бус замаар жолоодохыг хориглож, бэлчээрийн газрыг доройтлоос сэргийлнэ.

Харин барилгын ажлын улмаас зөвшөөрөлтэй талбайд малчдын чөлөөт хөдөлгөөнд зарим саад учрах, тоосжилт үүсэх, чанар муутай бэлчээрээр хангах доройтсон газар дээрх салхин паркийн барилгажих талбай зэрэг нь зайлшгүй үүсэх нөхцөл болно. Гэвч энэ нь нийт газрын зөвхөн 0.3% эвдрэлд орох тооцоо гарах бөгөөд үүнээс нутгийн малчдад үзүүлэх нөлөөлөл нь бага гэж үзсэн.

Дамжуулах шугамын дагуу болзошгүй эдийн засгийн нүүлгэн шилжилжүүлэлтийг одоогоор үнэлж байгаа б бодит нүүлгэн шилжүүлэлт тохиолдохгүй. Дамжуулах шугамын зурвас нь төрийн мэдэлд байх бөгөөд төслийн компаниас холбогдох зөвшөөрлийг авна. Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн улмаас шаардагдах аливаа нөхөн олговрыг Газар Чөлөөлөлтийн Ажлын Хүрээнд тусгасан алдагдсан бэлчээрийн газрын нөхөн олговрын хэлбэр ба аргачлалын дагуу тодорхойлж, шийдвэрлэнэ.

### Соёлын өв дурсгал

Салхин парк, дамжуулах шугамын төслийн талбайг олон улс ба үндэсний хэмжээнд танигдсан өв дурсгалд сөрөг нөлөөтэй гэж үзэхгүй. Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн харьяа Археологийн хүрээлэнтэй хийсэн зөвлөгөөнөөр Төслийн барилга угсралтын талбайн дотор ямар нэг соёлын чухал ач холбогдолтой нөөц байхгүй болохыг баталсан. Гэвч Цэций уул нь нутгийн иргэдэд соёлын тодорхой ач холбогдолтой юм.

---

---

Хэд хэдэн уул толгод дээрх овоонууд нь онцлох ач холбогдолгүй болохыг ойр орчмын оршин суугчид олон нийтээр хэлэлцүүлэх уулзалтын үеэр мэдэгдсэн. Гэсэн ч ямар нэг барилгын ажил уулын орой эсвэл нурууны шугамаар явагдахгүй тул эдгээр овоонууд нь сүйтгэгдэхгүй үлдэх ба барилгын шатны шууд нөлөөлөлд өртөхгүй юм.

Дамжуулах шугамын зурвас газрын дагуу ямарваа нэг мэдэгдсэн соёлын өв дурсгалт газар тогтоогдоогүй боловч суурийн малтлагын үед зарим нэг археологийн олдворыг илрүүлэх магадлалтай.

Одоогоор мэдэгдэж буй археологийн, шашны, байгалийн үзэмжит газрууд байхгүй тул төслийн талбайн нөлөөллийг бага гэж үнэлсэн. Үүний адилаар шууд нөлөөллийн цар хүрээг бага гэж үнэлсэн тул нийт нөлөөллийг ноцтой биш гэж үзсэн.

Барилгын шатанд булагдмал археологийн олдворыг (санамсаргүй олдвор) илрүүлэх боломжтой тул үүнд Санамсаргүй Олдворын Журмыг шаардана. Археологийн ач холбогдолтой зүйлийг илрүүлсэн тохиолдолд ажлыг зогсоох, олдворыг зохих эрх бүхий газарт мэдэгдэх, үнэлүүлэх, мөн ажилчдыг сургах алхмуудыг хийнэ.

#### Хам нөлөөлөл

Төслийн хам нөлөөлөл, ирээдүйд баригдах салхин цахилгаан станцын улмаас хам нөлөөлөл үүсэх талааруг БОННБҮ-ээр олж тогтоогоогүй болно. Уул уурхайн компаниудын өнөөгийн дарамт ачаалалыг суурь нөхцөл ба нийт нөлөөллийн үнэлгээнд харгалзан үзэж, авч хэлэлцсэн.

#### Ашиглалтнаас гаргах шат

Ашиглалтаас гаргахын өмнө уг үе шатанд хэрэгжүүлэх замын хөдөлгөөний менежментийн талаар холбогдох оролцогч талуудтай зөвшилцөнө. Ашиглалтнаас гаргасны дараа СЦҮ-үүд, автозамууд болон бусад бүтцүүдээр эзлэгдэж байсан талбайг хээрийн экосистемд эргүүлэн шилжүүлэх нөхөн сэргээлт чухал байна. Ашиглалтнаас гаргах үед зарим зүйл, ялангуяа бүс нутгийн хэмжээнд ховор зүйлүүдийн мэдрэг байдал нэмэгдчихсэн байх боломжтой.

Нөхөн сэргээх ажлын зэрэгцээ тос агуулах сав зэрэг бохирдсон материалыг талбайгаас зайлуулж, цаашид хөрс ба гүний ус бохирдуулахаас сэргийлэн зохих хаягдлын талбайд аваачих нь зүйтэй.

### 3.2 Нөлөөлөл бууруулах арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх вэ?

Төсөл хэрэгжих шатанд төлөвлөсөн нөлөөлөл бууруулах арга хэмжээний хэрэгжилтийг үр ашигтай удирдлагаар хангахын тулд байгаль орчны үнэлгээний үр дүн, олон нийт ба гол

оролцогч талуудтай хийсэн зөвлөгөөнд суурилсан Байгаль Орчин, Нийгмийн Арга Хэмжээний Төлөвлөгөөг (БОНАХТ) боловсруулна.

БОНАХТ нь Төслийн барилга, ашиглалтын шатанд зориулсан илүү дэлгэрэнгүй Байгаль Орчин, Нийгмийн Менежментийн Төлөвлөгөөнүүд (БОНМТ-үүд)-ээр дэмжигдэнэ. БОНМТ-үүд нь барилга угсралтын үе шатанд Инженерчлэл, Худалдан авалт, Барилга угсралтын (ИХАБУ) Гэрээлэгчээр, мөн ашиглалтын үе шатанд ирээдүйн талбайн оператороор боловсруулагдах илүү өргөн хүрээний байгаль орчны менежментийн систем (БОМС)-д ерөнхий бүдүүвч болж өгдөг. БОМС нь олон улсын ISO 14001 стандарттай нийцэх болно.

Олон улсын OHSAS 18001 стандарттай нийцэх эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны системийг боловсруулж хэрэгжүүлэх ба энэ үүнд ажилчдыг байрлуулах менежментийн төлөвлөгөө багтана.

Мөн ОТУТ-ний нэг хэсэг болгож нутгийн иргэдийн гомдол барагдуулах ерөнхий механизмыг боловсруулах ба үүнд сэлгэн суурьшуулалтын улмаас үүссэн эдийн засгийн гомдлоос эхлээд оролцогч талуудын ерөнхий гомдлуудыг цуглуулах, хариулах заалтууд багтана.

Төсөл хэрэгжүүлэгч компани болон ИХАБУ-н гэрээлэгч нь барилга угсралт, ашиглалтын шатанд байгаль орчин ба нийгмийн менежмент, оролцогч талуудын уулзалтыг хариуцах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны мэргэжилтэн, мөн олон нийтийн харилцах мэргэжилтнийг (ОНХМ) авч ажиллуулна.



## 4 НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

### 4.1 Төслийн тухай илүү дэлгэрэнгүй мэдээллийг хэрхэн авах вэ?

Клин Энержи Азиа ХХК нь олон нийтэд зориулан мэдээллийг нийтлэн ил болгох, төслийн оролцогч талуудтай хийх уулзалтыг чиглүүлж удирдах Оролцогч Талуудын Уулзалтын Төлөвлөгөөг боловсруулсан. Үндсэн оролцогч талуудыг олж тогтоосон ба цаашид олон нийт ба илүү өргөн хүрээний оролцогч талуудад зориулан мэдээллийг нийтлэх, ил болгох үйл явцын хөтөлбөрийг боловсруулсан болно. Төсөл хэрэгжүүлэх компани БОНБНҮ, БОННБҮ, Байгаль орчин ба Нийгмийн Арга Хэмжээний Төлөвлөгөө болон ОТУТ-г олон нийтэд ил болох үед эсвэл түүнээс өмнө ОНХМ-ийг томилно. ОНХМ нь оролцогч талуудын уулзалт болон гомдлуудыг хариуцаж ажиллана.

Төсөл хөгжүүлэгч компанитай холбоо барих мэдээлэл нь одоогоор түр зуурынх бөгөөд ОНХМ-ийг томилсон даруй шинэчлэх болно. Гэсэн ч илүү мэдээллийг авах бүхий л хүсэлтийг доорх холбоо барих хаягаар хүлээн авна.

**Холбоо барих нэр:** Мөнх-Очирын Бямбахишиг

byambakhishig@newcom.mn

**Орон нутгийн хаяг:** Төслийн талбайг байгуулах үед батлагдана.

**Утасны дугаар:** +976 11 345 252

**Улаанбаатарын хаяг:** Найман Зовхис барилга, 10-р давхар  
21 Сөүлийн гудамж  
Улаанбаатар 14251  
Монгол

**Telephone number:** +976 313183 (43)

**Email:** byambakhishig@newcom.mn

### 4.2 Би хэлэх үгээ хэрхэн хүргэх вэ?

Хавсралт А-д өгөгдсөн стандарт Санал гомдлын Маягтыг бөглөж шуудангаар эсвэл и-мэйлээр орон нутгийн оффист хүргүүлэх, эсвэл дээрх утасны дугаараар компани руу утасдаж бүхий л санал хүсэлт, гомдолоо ирүүлэх боломжтой.

## ХАВСРАЛТ: Олон нийтийн гомдол, хүсэлтийн маягт

<i>Хэрвээ та нэрээ мэдэгдэхийг хүсэхгүй бол дараах эхний гурван мөрийг бөглөхгүй үлдээнэ үү.</i>													
Овог нэр													
Холбоо барих мэдээлэл <i>Тантай хэрхэн холбоо барихыг хэлнэ үү (ө.х. шуудан, утас эсвэл и-мэйл). Нэрээ мэдэгдэхийг хүсэхгүй бол бөглөхгүй орхино уу.</i>	Шуудангийн хаяг:  Утасны дугаар: И-мэйл хаяг:												
Илүүд үзэх хэл (хайрцагийг зөвлөнө үү)	<table style="width: 100%; border: none;"> <tr> <td style="width: 33%;">Монгол</td> <td style="width: 33%; text-align: center;"><input type="checkbox"/></td> <td style="width: 33%;">Орос</td> <td style="text-align: center;"><input type="checkbox"/></td> </tr> <tr> <td>Хятад</td> <td style="text-align: center;"><input type="checkbox"/></td> <td>Англи</td> <td style="text-align: center;"><input type="checkbox"/></td> </tr> <tr> <td>Бусад</td> <td style="text-align: center;"><input type="checkbox"/></td> <td></td> <td></td> </tr> </table>	Монгол	<input type="checkbox"/>	Орос	<input type="checkbox"/>	Хятад	<input type="checkbox"/>	Англи	<input type="checkbox"/>	Бусад	<input type="checkbox"/>		
Монгол	<input type="checkbox"/>	Орос	<input type="checkbox"/>										
Хятад	<input type="checkbox"/>	Англи	<input type="checkbox"/>										
Бусад	<input type="checkbox"/>												
<i>Хэрвээ та нэрээ мэдэгдэхийг хүсэхгүй бол дараах мөрнөөс эхлэн бөглөнө үү.</i>													
Эргэх холбоо буюу гомдлыг тайлбарлана уу (Юу болсон? Хаана болсон? Хэнд тохиолдсон? Асуудлын үр дагавар юу болох?):													
Хэрэг /санал гомдлын огноо													
Нэг удаагийн хэрэг / гомдлын огноо.....													
Нэгээс олон удаа тохиолдсон уу? Хэдэн удаа? .....													
Үргэлжилсээр байгаа (ө.х. одоо асуудалтай тулгарч байгаа) Тийм / Үгүй (дугуйлна уу)													
Асуудлуудыг хэрхэн шийдвэрлүүлэх хүсэлтэй байна вэ?													
Гарын үсэг.....Огноо.....													
Маягтыг дараахи газарт хүргүүлнэ үү: КЭА Цэций салхин парк эсвэл доор дурьдсан санал гомдлын хайрцагийн аль нэгт.													
Санал гомдлын хайрцагийн байршил: [тодорхойлох]													
(Зөвхөн албаны хэрэгцээнд) Санал гомдлын дугаар:													